

- Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангаар цэвэр ашгийн хэмжээ 2.5%-иас дээш байх;
- Хүсэлт болгож буй төслийн хэмжээг хангах барьцаа хөрөнгө;
- Төслийн нийт зардлын 15-аас доошгүй хувийг бэлэн мөнгө болон бусад хэлбэрээр өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлэх чадвартай байх;
- Төслийн санхүүгийн дотоод өгөөж нь хөрөнгийн жигнэсэн дундаж өртгөөс их байх;
- Төслийн эдийн засгийн дотоод өгөөж нь 12%-иас дээш байх;
- Түүхий эдийн найдвартай нийлүүлэлт хийгдэх суурийг тавьсан, бэхжүүлэх, өргөтгөх төлөвлөгөөний үндэслэл сайн;
- Барилга байгууламж, газар худалдан авах бол талуудын худалдан авах буюу түрээсээр ашиглах албан ёсны гэрээ байгуулсан байх;
- Монгол улсад мөрдөгдөж буй Байгаль орчны хууль тогтоомжийн шаардлагыг хангасан байх (Санхүүжилт авах төсөлд байгаль орчны анхан шатны үнэлгээг хийлгэсэн, анхан шатны үнэлгээгээр дэлгэрэнгүй үнэлгээ хийх шаардлага тавигдсан бол дэлгэрэнгүй үнэлгээ хийлгэж, БОАЖЯ -аар батлуулсан байх);
- Монгол улсад мөрдөгдөж буй эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын стандартыг хангаж буйг Мэргэжлийн Хяналтын байгууллагаар баталгаажуулсан байх;
- Зээлийн материалын бүрдэл бүрэн байх;
- Хөдөлмөрийн зохистой харилцааг хууль тогтоомж, Нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд хангаж ажилладаг байх.